



Монгол Улсын хэдэг
ч 06 дугаар сарын 03
НДТ / 6907

Монгол Улсын
хууль

941

Монгол Улсын
өнхийлгэчийн
зарлиг

979

Монгол Улсын
эсгийн газрын
тогтоол

979

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Эрүүл мэндийн тухай

Элчин сайдыг томилох тухай

Зарим байгууллагын байршлыг
тогтоох тухай

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

228.	Эрүүл мэндийн тухай	941
229.	Эрүүл мэндийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	978
230.	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшнөөрчийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	978

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

231.	Элчин сайдыг томилох тухай	Дугаар 97	979
------	----------------------------	-----------	-----

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

232.	Зарим байгууллагын байршилыг тогтоох тухай	Дугаар 94	979
233.	Зөвлөл байгуулах тухай	Дугаар 95	982
234.	Монгол Улсын иргэд "Эрдэнэ Тавантолгой" компанийн хувьцааг эзэмшиүүлэх тухай	Дугаар 98	987

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 05 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, үндсэн зарчмыг тодорхойлж, иргэний эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрхийг хангахад аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэний гүйцэтгэх үүрэг, эрүүл



мэндийн байгууллага, ажилтны үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Эрүүл мэндийн тухай хууль тогтоомж

2.1. Эрүүл мэндийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өврөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрднө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "Эрүүл мэнд" гэж хүн өвчин, эмгэгтүй, бие бялдар, оюун санаа, нийгмийн амьдралын хувьд сайн сайхан байхыг;

3.1.2. "Эрүүл мэндийг хамгаалах" гэж хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг зохион байгуулах замаар хүн амын эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн анагаах ухаан, нийгэм, эдийн засгийн цопц арга хэмжээг;

3.1.3. "Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ" гэж нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусlamж, үйлчилгээг;

3.1.4. "Эрүүл мэндийн байгууллага" гэж хүн амд эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ үзүүлэх зорилго, үндсэн чиг үүрэг бүхий хуулийн этгээдийг;

3.1.5. "Эмнэлгийн мэргэжилтэн" гэж хүний их, бага эмч, нүүр-амны их эмч, сувилагч, эм зүйч, эх барич, эм найруулагч, нийгмийн эрүүл мэндийн болон анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллеж тэгссэн эмнэлгийн бусад ажилтныг;

3.1.6. "Эрүүл мэндийн ажилтан" гэж эмнэлгийн мэргэжилтэн болон эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа бусад ажилтныг;

3.1.7. "Олон улсын хел хориот өвчин" гэж Олон улсын эрүүл мэндийн дүрэмд эзласан өвчинийг.

¹ Монгол Улсын Үндсэн хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дугаартийн тогтолцоогийн



3.1.8."идэвхжсон голомтыг цомхотгох" гэж мал, амьтнаас хүнд халдвартай байгалийн голомтот халдварт өвчиний байгалийн голомт идэвхжих буюу өвчин гарсан үед голомтыг зруулжүүлэх арга хэмжээ авахыг;

3.1.9."эмчлэх" гэж өвчиний оношлох, здгэрүүлэх, өвчтөнийг сэргээн засах, өвчлөхөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн эмчийн мэргэжлийн цогц үйл ажиллагааг;

3.1.10."сувилах" гэж өвчлөхөөс урьдчилан сэргийлэх, өвчинийг здгэрүүлэх, өвчтөнийг сэргээн засахад чиглэсэн сувилгачийн мэргэжлийн цогц үйл ажиллагааг;

3.1.11."эх барих" гэж жирэмсний, төрөх, төрсний дараах үед эх, ураг, нярайг оношлох, хянах, терелтийг удирдах, эмчлэх, өвчлөхөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн мэргэжлийн цогц үйл ажиллагааг;

3.1.12."эм барих" гэж эм зүйн шинжлэх ухааны дагуу эмийг найруулах, савлан бэлтгэх, шалгаж олгох үйл ажиллагааг;

3.1.13."эмнэлгийн тоног төхөөрөмж" гэж хүний бие махбодийн бүтэц, үйл ажиллагаа, өвчин, эмгэг, согогийг оношлох, эмчлэх, сэргээн засах, хянах зориулалтаар бүтээгдсэн бие даасан ажиллагаа бүхий зүйлийг;

3.1.14."эмнэлгийн багаж" гэж хүний бие махбодийн бүтэц, үйл ажиллагаа, эмгэг, согогийг оношлох, эмчлэх, сувилах, сэргээн засах, хянах зориулалтаар бүтээгдсэн болон гараар хийх үйлдэлд хэрэглэх зүйлийг;

3.1.15."эмнэлгийн тоног төхөөрөмжийн дагалдах хэрэгсэл" гэж эмнэлгийн тоног төхөөрөмжийг хэвийн ажиллуулахад зайншигүй шаардагдах туслах хэрэгслийг;

3.1.16."протез" гэж хүний эд, эрхтнийг орлуулах болон эмгэг, согогийг засах зориулалтаар бүтээгдсэн зүйлийг;

3.1.17."зруул мэндийн байгууллагын магадлан итгэмжлэл" гэж зруул мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагаа, эмнэлгийн туслаамж, үйлчилгээний технологи, чанарт хөндлөнгийн үнэлгээ хийж, дүнгэлт гаргахыг;



3.1.18."донор" гэж Донорын тухай хуулийн² 3.1.2-3.1.4-т заасныг;

3.1.19."эрүүл мэндийг дэмжих" гэж хүн амын эрүүл мэндийг хянах, бахжуулэх, хүн амд эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, эрүүл аж төрөх орчныг бүрдүүлэхэд чиглэсэн цогц үйл ажиллагааг.

4 дүгээр зүйл. Эрүүл мэндийн талаар тороос баримтлах бодлого, үндсэн зарчим

4.1. Тороос хүн амын эрүүл мэндийн талаар дараах бодлогыг хэрэгжүүлнэ:

4.1.1. хүн амын эрүүл мэндийг төрийн онцгой анхаарал, ивээлд авах;

4.1.2. хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг ялгаварлан гадуурхахгүйгээр тэгш, хүртээмжтэй үзүүлэх;

4.1.3.өмчийн хэлбэр харгалзахгүйгээр эрүүл мэндийн байгууллагад адил тэгш хандах;

4.1.4. Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн зарим төрлийн тусламж, үйлчилгээний төлбөрийг төр хариуцах.

4.2. Энэ хуулийн 4.1-д заасан бодлогыг хэрэгжүүлэхэд дараах үндсэн зарчим баримтална:

4.2.1. хүмүүнлэг, энэргийн үс, шинжлэх ухааны мэдлэг, ополт, нотолгоо, орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны дэвшилтэгт аргад тулгуурлан хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх;

4.2.2. нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгож, улмаар эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэхэд эрүүл мэндийн байгууллагын бие даасан, нээлттэй, өмчийн олон хэлбэрт тулгуурласан байдлыг хангах;

4.2.3. эрүүл мэндийн бодлого, арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллага, нутгийн захиргааны болон нутгийн веерее удирдах байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, хамт олон, гэр бүл, иргэний нэгдмэл үүп ажиллагаагаар хэрэгжүүнэк.

² Донорын тухай хууль - "Төрийн мэдээлэл" эм. тгийн 2000 оны 6 дугаарт ийтгөгдсөн.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ЭРҮҮЛ МЭНДИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

5 дугаар зүйл. Эрүүл мэндийн удирдлагын тогтолцоо

5.1. Эрүүл мэндийн удирдлагын тогтолцоо нь Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага, эрүүл мэндийн байгууллагын удирдлагаас бүрдэнэ.

6 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын бүрэн эрх

6.1. Монгол Улсын Их Хурал эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1. төреөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг тодорхойлох;

6.1.2. эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар Засгийн газраас зохион байгуулж байгаа ажилд хяналт тавих;

6.1.3. онц байдлын үед хүн амын эрүүл мэнд, амьнасыг хамгаалах асуудлаар эрүүл мэндийн байгууллага, иргэн, бусад байгууллагын үүргийг тодорхойлох;

6.1.4. эрүүл мэндийн асуудлаар олон улсын гэрээнд Монгол Улс нэгдэн орох, цуцлах асуудлыг шийдвэрлэх;

6.1.5. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

7 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрх

7.1. Монгол Улсын Засгийн газар /цаашид "Засгийн газар" гэх/ эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 9 дүгээр зүйлд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1. төреөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

7.1.2. эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах;

7.1.3. эрүүл мэндийн талаар үндэсний хөтөлбөр баталж,



санхүүжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;

7.1.4.эрүүл мэндийн салбар дахь хамтын ажиллагаваны асуудлаар бөрийн бүрэн эрхийн хүрээнд бусад улсын Засгийн газар, олон улсын байгууллагатай гэрээ, хэлэлцээр хийх;

7.1.5.зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлэх иргэнд санхүүжилт олгох журмыг батлах;

7.1.6.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

7.2.Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэд төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг улсын хэмжээнд зохицуулах үүрэг бүхий орон тооны бус Үндэсний зөвлөл байгуулан ажиллуулж болно.

7.3.Энэ хуулийн 7.2-т заасан Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Монгол Улсын Ерөнхий сайд батална.

8 дугаар зүйл.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

8.1.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.1.эрүүл мэндийн тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах;

8.1.2.хүн амын эрүүл мэндийн байдлыг судлах, хянах, үнэлэх, эрэлт хэрэгцээг үндэслэн эрүүл мэндийн салбарын бодлого, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох;

8.1.3.бүсийн оношлогоо, эмчилгээний төв, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, уламжлалт анагаах ухааны төв корпорацийг мэргжинл, арга зүйн удирдлагагаар хангах;

8.1.4.хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг салбарын хэмжээнд төлөвлөх, зохион байгуулах, эрүүл мэндийн байгууллагын байршил, бүтэц, зохион байгуулалт, тусламж, үйлчилгээний төрөл, шатлал, эмнэлгийн болон сувиллын орны дээд хязгаарыг тогтоох;

8.1.5.хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих



талаар иргэд, төрийн болон төрийн бус байгууллагад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

8.1.6.хүн амын эрүүл мэндийг хамгаалах, болжуулзах, үндэсний хөтөлбөр, тесел боловсруулах, хэрэгжилтийг зохицуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг тооцох;

8.1.7.эрүүл мэндийн тулгамдсан асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг захиалан гүйцэтгүүлэх;

8.1.8.эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжлийн бодлогыг тодорхойлон хэрэгжүүлэх;

8.1.9.эмнэлгийн мэргэжилтнийг мэргшүүлэх, давтан сургах бодлогыг тодорхойлж, хэрэгжилтийг хангуулах, эрүүл мэндийн мэргэжлийн чиглэл, индекс, анагаах ухавын боловсролын сургалтын байгууллагын элсэлтийн хяналтын тоо, сургалтын түшиц эмнэлгээр хангах асуудлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллагатай хамтран шийдвэрлэх;

8.1.10.эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг хангах асуудлыг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэх;

8.1.11.эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийн бодлогыг тодорхойлох, төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

8.1.12.эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн бодлогыг холбогдох байгууллагатай хамтран тодорхойлох;

8.1.13.аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, хянах;

8.1.14.эрүүл мэндийн удирдлалаа, мэдээллийн тогтолцооны бодлогыг тодорхойлох, мэдээлэлээр хангах;

8.1.15.эрүүл мэндийн асуудлаар төрийн бус байгууллага болон гадаад улс, олон улсын байгууллагатай хамтран ажиллах;

8.1.16.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

8.2.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллагын дэргэд эрүүл мэндийн салбарын бодлого, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, эрүүл мэндийн тухай хууль тогтоомж, Засгийн

газрын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулахад нь зөвлөх чиг үүрэг бүхий орон тооны бус мэргэжлийн зөвлөл байгуулан ажиллуулж болно.

8.3. Энэ хуулийн 8.2-т зассан мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын пишүүн батална.

9 дүгээр зүйл. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх

9.1. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.1. эрүүл мэндийн тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх;

9.1.2. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, эрүүл мэндийн байгууллага, үйлдвэрлэлийн стандартыг боловсруулах;

9.1.3. эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулах;

9.1.4. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын бодлогыг хэрэгжүүлж, эрүүл мэндийн байгууллагад магадлан итгэмжлэл олгох үйл ажиллагааг зохион байгуулах;

9.1.5. эрүүл мэндийн статистик мэдээллийг настгтан гаргах, мэдээлэх;

9.1.6. эрүүл мэндийн салбарын хөгжил, эрүүл мэндийн ажилтны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангах, судалгаа хийх;

9.1.7. иргэний эрүүл мэндээ хамгаалах, евчлөхөөс урьдчилсан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа хийх, эрүүл мэндийг дэмжих арга хэмжээг зохион байгуулах;

9.1.8. эмийг бүртгэх, баталгаажуулах үйл ажиллагааг зохион байгуулж, эмийн чанар, аюулгүй байдлын талаар нийтэд мэдээлэх;

9.1.9. эрүүл мэндийн ажилтныг төгсөлтийн дараах



сургалтад хамруулах, мэргэшлэйн зэрэг олгох үйл ажиллагааг зохион байгуулах;

9.1.10.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

10 дугаар зүйл.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх

10.1.Аймаг, нийслэл, сум, дүүрэгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.1.1.эрүүл мэндийн тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;

10.1.2.харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийн асуудлаар Засаг даргын тайлан, мэдээллийг хэлэлцэн дүгнэлт огех;

10.1.3.харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар хетелбер, шийдвэр гаргаж, хэрэгжилтэд хяналт тавих;

10.1.4.харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих арга хэмжээнд төрийн болон териин бус байгууллага, иргэний хамтын оролцоог хангаж, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах;

10.1.5.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

11 дүгээр зүйл.Бүх шатны Засаг даргын бүрэн эрх

11.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.1.1.эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газар, нутгийн веерэе удирдах байгууллагаас гаргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;

11.1.2.харьяалах нутаг дэвсгэртээ хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, ойрын ба хэтийн төловийг тодорхойлсон хетелбер, төсөл боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж, гарсан



шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;

11.1.3.эруул мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшүүлцөн харьяалах нутаг дэвсгэрийнхээ эзүүл мэндийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, оновчтой байршуулах, материаллаг бааз, хүний болон санхүүгийн неоцийг зохистой хуваарилах;

11.1.4.байгалийн онц аюултай узэгдэл болон олон улсын хөл хориот өвчин гарсан тохиолдолд шаардлагатай арга хэмжээг шурхай авах;

11.1.5.эзүүл мэндийг хамгаалах, дэмжих чиглэлээр идэвх, санаачилгатай ажиллаж байгаа хамт олон, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах, сурталчлах ажлыг зохион байгуулах;

11.1.6.аймаг, нийслэлийн эзүүл мэндийн газрын даргыг эзүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын пишүүнтэй зөвшүүлцен Төрийн албаны тухай хуулийн дагуу томилох, чөлөөлөх;

11.1.7.харьяалах нутаг дэвсгэрийн эзүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтний нийгмийн баталгааг хангах, тогтвортой суурьшилтай ажиллах нохцолийг бурдуулж ажлыг зохион байгуулах;

11.1.8.харьяалах нутаг дэвсгэрийн эзүүл мэндийн байгууллагад номолт санхүүжилт олгох;

11.1.9.тухайн шатны эрүүл мэндийн байгууллагын удирдлагыг томилох, чөлөөлөх асуудлаар эзүүл мэндийн газрын даргатай зөвшүүлцөх;

11.1.10.хууль тогтоомжид засан бусад бүрэн эрх.

11.2.Сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга эзүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.2.1.эзүүл мэндийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газар, нутгийн veree удирдах байгууллага, дээд шатны Засаг даргаас таргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;

11.2.2.харьяалах нутаг дэвсгэрийн хүн амд үзүүлэх эзүүл мэндийн тусламж, үйлчилгээний тэгүү, хүртээмжтэй байдлыг хангах;

11.2.3.эрүүл мэндийг хамгаалах, дэмжих чиглэлээр нийтийг хамарсан арга хэмжээнд аж ахуйн нэгж, байгууллага, иргэний татан оролцуулах ажлыг зохион байгуулах;

11.2.4.харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагыг шаардлагатай боловсонхүчин, материаллагбааз, санхүүгийн хувьд бэхжүүлэх;

11.2.5.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

11.3.Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн даргыг тухайн шатны Засаг дарга, аймгийн эрүүл мэндийн газрын даргатай зөвшилцэж томилж, чөлөөлно.

12 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын бүрэн эрх

12.1.Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлэх:

12.1.1.эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргаас гаргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;

12.1.2.улсын хэмжээний үйлчилгээтэй болон гадаадын хөрөнгө оруулалттайгаас бусад эрүүл мэндийн байгууллага байгуулах, түүнд тусгай зөвшөөрөл олгох эсэх асуудлаар санал, дүтнэлт гаргаж, тухайн шатны Засаг даргад танилцуулах;

12.1.3.эмнэлгийн орыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагасаас тогтоосон хязгаарт багтаан зохицуулах;

12.1.4.харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагавар хангаж, хяналт тавих;

12.1.5.харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийн статистик мэдээлэл, эрүүл мэндийн байгууллагын тайлан, мэдээ, мэдээллийг нэгтгэн холбогдох байгууллагад өгөх.

12.2.Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нь тухайн шатны Засаг даргатай зөвшилцэж, харьяа эрүүл мэндийн байгууллагын

даргыг хууль тогтоомжид заасны дагуу томилж, чөлөөлийн.

**ГУРАВДУГААР БҮЛЭГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОРӨЛ**

13 дугаар зүйл. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний торол

13.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ дараах төрлөтэй байна:

13.1.1. нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ;

13.1.2. эмнэлгийн тусламж, үйлчилгээ.

13.2. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөхөнлөх хүчин зүйлийг тандах, судлах, хянах, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагаа хамаарна.

13.3. Эрүүл мэндийн байгууллага нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг дангаарва болон бусад аж ахуйн нэгж, байгууллага, олон нийт, иргэдтэй хамтран явуулна.

13.4. Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд дараах үйл ажиллагаа хамаарна:

13.4.1. үйлчилгээний эрүүл мэндийн байдалд үзүүлгээ егех, оношлогоо, эмчилгээний үйлдэл, ажилбар хийх, мэргэжлийн дүнгэлт гаргах, хянах, сэргээн засах, сэхээн амьдроулах тусламж үзүүлэх цогц үйл ажиллагаа;

13.4.2. цочмог өвчин, эмгэг, осол, гэмтэл, хордлого, төрөх үед эмнэлгийн яаралтай аюхны тусламжийг газар дээр нь болон тээвэрлэх явацад үзүүлэн, эмнэлэгт хүргэх түргэн тусламжийн үйлчилгээ;

13.4.3. гэнэтийн өвчин, осол, гэмтэл, хордлого болон төрөх үед хамгийн ойр байрлах эрүүл мэндийн байгууллагас үзүүлэх эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээ;

13.4.4. эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэнийг эрүүл мэндийн байгууллагад зориулалтын унаагаар тээвэрлэн хүргэх түргэн тусламжийн үйлчилгээ;

13.4.5. өвчин, эмгэг, гэмтэл бэртлийн улмаас үүссэн

ур дагаврыг арилган хэвийн байдалд оруулахад чиглэсэн сэргээн засах тусlamж, үйлчилгээ;

13.4.6.чанар, ноөц нь тогтоогдсон раашан ус, шавар, байгалийн бусад хүчин зүйлийг ашиглаж сэргээн засах тусlamж, үйлчилгээ;

13.4.7.хүн амыг олноор хамарсан халдварт очиний дэгдэлт болон аюулт үзэгдлийн үед голомтыг хязгаарлах, цомхотгох, хохирлыг багасгахад чиглэсэн эрүүл мэндийн байгууллагын дангаар болон тэр, олон нийт, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдтэй хамтран узуулэх гамшигийн үеийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ.

13.5.Сэргээн засах тусlamж, үйлчилгээ узуулэх хүрээ, эмчилгээ, оношлогооны журам, очиний жагсаалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

13.6.Гамшигийн үеийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг Гамшигаас хамгаалах тухай хуулийн³ 17.1.2-т заасан эрүүл мэндийн албан хуулийн 18.1.1-д заасны дагуу зохион байгуулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦОО

14 дүгээр зүйл.Эрүүл мэндийн байгууллагын тогтолцоо

14.1.Эрүүл мэндийн байгууллагын тогтолцоо нь нийгмийн эрүүл мэндийн, эмнэлгийн тусlamж, үйлчилгээний, зам хангамжийн, анагаах ухааны боловсрол, эрдэм шинжилгээ, сургалтын үйл ажиллагаа хариуцсан төрийн, хувийн хэвшлийн, холимог бичийн эрүүл мэндийн байгууллагаас бүрдэнэ.

15 дугаар зүйл.Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ узуулэх байгууллагын төрөл

15.1.Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ узуулэх байгууллага дараах төрөлтэй байна:

- 15.1.1.өрхийн эрүүл мэндийн төв;
- 15.1.2.сум, тосгоны эрүүл мэндийн төв;
- 15.1.3.сум дундын эмнэлэг;
- 15.1.4.клиник;

³ Гамшигаас хамгаалах тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэхийн 2003 оны 25 дугаартийн тогтолцоо.

- 15.1.5.амаржих газар;
- 15.1.6.нийгийн эрүүл мэндийн төв;
- 15.1.7.нэгдсэн эмнэлэг;
- 15.1.8.сувиалат;
- 15.1.9.түргэн тусламжийн төв;
- 15.1.10.бүсийн оношлогоо, змчилгээний төв;
- 15.1.11.төв эмнэлэг;
- 15.1.12.тусгай мэргэжлийн төв.

15.2.Энэ хуулийн 15.1.10-15.1.12-т заасан байгууллага нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллагын харьяанд ажиллана.

16 дугаар зүйл. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын чиг үүрэг

16.1.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг энэ хуулийн 15.1-д заасан байгууллага үзүүлнэ.

16.2.Өрхийн эрүүл мэндийн төв нь хот, суурин газрын хүн амд төрөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх үндсэн чиг үүрэг бүхий сайн дурын үндсэн дээр бүртгүүлсон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага байна.

16.3.Өрхийн эрүүл мэндийн нэг төвд ногдох иргэний тоог Засгийн газар тогтооно.

16.4.Өрхийн эрүүл мэндийн төви һүн үлгэрчилсан дурмийг Засгийн газар батална.

16.5.Өрхийн эрүүл мэндийн төв эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэхд төрийн болон өрон нутгийн омч, хоренгийг төлбөргүйгээр ашиглах журмыг хуулиар тогтоочоно.

16.6.Өрхийн эрүүл мэндийн төвийн удирдлага, зохион байгуулалтын асуудлыг Иргэний хууль^{*} болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

16.7.Сум, тосгоны эрүүл мэндийн төв нь харьяа нутаг дэвсгэрийнхээ хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг орчин үеийн болон уламжлалт анагаах ухваны аргаар үзүүлэх бөгөөд сумын эрүүл мэндийн төв нь тухайн сумын хүн амын тоо, байршилаас хамааран багийн

* Иргэний хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгээлийн 2002 оны 7 дугаарт ийтгэгдсэн.

эмчийн салбартай байж болно.

16.8. Сум дундын эмнэлгэ нь хүн амын суурьшил, нягталаас хамааран харьяаллын болон эзргэлдээ сумын хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлнэ.

16.9. Клиник нь хүн амд эмнэлгийн тусламж, үйлчилгээг төрөлжсөн хэлбэрээр үзүүлнэ.

16.10. Амаржих газар нь хот, суурин газрын хүн амд эх барих, эмэгтэйчүүд болон нярайн тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллага байна.

16.11. Нийгмийн эрүүл мэндийн төв нь нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх үйл ажиллагааг аймаг, дүүргийн түвшинд зохион байгуулна.

16.12. Нагдсон эмнэлг нь хүн амд 7-гоос доошгүй чиглэл /дотор, хүүхэд, эх барих, эмэгтэйчүүд, ерөнхий мэс засал, шуд, мэдрэл, халдварт/-ээр эмнэлгийн тусламж, үйлчилгээг амбулатори болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх бөгөөд хүн амын байршил, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээг үндэслэн салбар амбулаторитой байж болно.

16.13. Сувилал нь хүн амд мэс заслын бус аргаар сэргээн засах, асаргаа сувилгаа хийх үндсон чиг үүрэг бүхий эрүүл мэндийн байгууллага байна.

16.14. Түргэн тусламжийн төв нь цочмог авчин, эмгэг, осол, гэмтэл, хордлого, жирэмслэлт, төрөх үед эмнэлгийн яаралтай анхны тусламжийг газар дээр нь болон тээвэрлэх явцад үзүүлэх эрүүл мэндийн байгууллага байх бөгөөд хот, суурин газрын хүн амын суурьшил, нягталаас хамаарч салбартай байж болно.

16.15. Бусийн оношлогоо, эмчилгээний төв нь бус нутгийн хүн амд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийн бусад байгууллагад мэргэжлийн аргачилсан зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах чиг үүрэг бүхий эрүүл мэндийн байгууллага байх бөгөөд бусийн оношлогоо, эмчилгээний төвийн үргэлжилсэн дурмийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

16.16. Төв эмнэлг нь улсын хэмжээнд төрөлжсөн мэргэжлээр эмнэлгийн тусламж, үйлчилгээг амбулатори болон хэвтүүлэн эмчлэх



хэлбэрээр үзүүлэх, сургалт, судалгааны ажил эрхлэх, зруул мэндийн бусад байгууллагыг лавлагаа, мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллана.

16.17. Тусгай мэргэжлийн төв нь улсын хэмжээнд тухайн мэргэжлээр эмнэлгийн тусламж, үйлчилгээг амбулатори болон хзватуулэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх, лавлагаа, сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэн зруул мэндийн бусад байгууллагыг мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллана.

17 дугаар зүйл. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний байгууллагын удирдлага

17.1. Бүсийн оношлогоо, эмчилгээний төв, төв змнэлэг, тусгай мэргэжлийн төв нь орон тооны бус Удирдах зөвлөлтэй байж болно.

17.2. Энэ хуулийн 17.1-д заасан Удирдах зөвлөлийн гишүүнийг З жилийн хугацаагаар эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилох ба Удирдах зөвлөлийн даргыг Удирдах зөвлөлийн гишүүд дотроосоо сонгоно.

17.3. Удирдах зөвлөлийн үйл ажиллагаагаа явуулах үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд Удирдах зөвлөл бүрэн эрхийнхээ хугацаанд жилд 2-оос доошигүй удаа хуралдана.

17.4. Энэ хуулийн 17.1-д заасан эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал тодорхой асуудлаар Удирдах зөвлөлийг хуралдуулах саналыг Удирдах зөвлөлийн даргад тавьж болно.

17.5. Удирдах зөвлөл олонхийн санглаар шийдвэр гаргана.

17.6. Удирдах зөвлөлийн даргыг үүргээ хангалтгуй билүүлсэн, хууль тогтоомж зерчсэн нь нотлогдсон, өөрөө чөлөөлөгдхөхийг хүссэн үндэслэлээр хугацаанаас нь өмнө өөрчилж болно.

17.7. Удирдах зөвлөл дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

17.7.1. холбогдох хууль тогтоомжийн дагуу эрүүл мэндийн байгууллагыг хөгжүүлэх бодлого, төлөвлөгөө, дотоод журмыг батлах, өөрчлөх, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох;

17.7.2. байгууллагын төсвийн төлөвлөгөөг батлах, хөрөнгө оруулалт, төсвийн зарцуулалтад хяналт тавих;

17.7.3. байгууллагыг хүний неецийн хөгжлийн төлөвлөгөөг

батлах, хэрэгжилтийг хянах;

17.7.4.эмнэлгийн тусlamж, үйлчилгээний чанарын хотолборийн хэрэгжилтийг хянах, чанар, хуртэмжийн байдалд үнэлэлт өгөх;

17.7.5.байгууллагын болон дарга, захирлын үйл ажиллагааны тайланг хэлэлцэх, үнэлэлт дүгнэлт өгөх;

17.7.6.байгууллагын санхүүгийн болон аудитын тайланг хэлэлцэж, шийдвэр гаргах;

17.7.7.аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс хандив, тусlamж авах, түүнийг зарцуулах журам тогтоох.

18 дугаар зүйл. Эрүүл мэндийн байгууллагыг улсын бүртгэлд бүртгэх

18.1.Эрүүл мэндийн байгууллагыг улсын бүртгэлд бүртгэх үйл ажиллагааг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн териин захиргааны төв байгууллага зохион байгуулна.

18.2.Эрүүл мэндийн байгууллагыг улсын бүртгэлд бүртгүүлж, хуулийн этгээдийн гэрчилгээ авснаар байгуулагдсанд тооцно.

18.3.Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосны дараа улсын бүртгэлд бүртгүүлсэн хуулийн этгээдийн гэрчилгээнд оруулах нэмэлт, верчлелтийг зруул мэндийн асуудал эрхэлсэн териин захиргааны төв байгууллага болон түүнээс эрх олгосон байгууллага хариуцан гүйцэтгэнэ.

18.4.Тусгай зөвшөөрөл авсан эрүүл мэндийн байгууллага нь хуулийн этгээдийн гэрчилгээнд нэмэлт, верчлелт оруулахад шаардагдах материялаа 30 хоногийн дотор энэ хуулийн 18.3-т заасан байгууллагад ирүүлнэ.

19 дүгээр зүйл. Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох

19.1.Зориулалтын барилга байгууламж, техник хэргэсэл, мэргэжлийн боловсон хүчин бүхий, емчийн аль ч хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож болно.



19.2.Улсын хэмжээний үйлчилгээтэй болон гадаадын хөрөнгө оруулалттай эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллага, эрүүл мэндийн бусад байгууллагад аймаг, нийслэлийн Засаг дарга тус тус мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл /цаашид "тусгай зөвшөөрөл" гэх/ олгоно.

19.3.Тусгай зөвшөөрөл авахад Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн² 11.1-д зааснаас гадна дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

19.3.1.үүсгэн байгуулагчийн шийдвэр;

19.3.2.эрүүл мэндийн байгууллагын дүрэм, үзүүлэх тусламж, үйлчилгээний төрөл, хүчин чадал, тооцоо;

19.3.3.эмнэлгийн мэргэжилтний бураандажхүүн, энэ хуулийн 25 дугаар зүйлд заасан мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл;

19.3.4.эмнэлгийн барилга байгууламж нь үзүүлэх тусламж, үйлчилгээний төрөл, хүчин чадалд тохирсон болон эрүүл ахуйн шаардлага хангасан тухай холбогдох байгууллагын дүгнэлт;

19.3.5.эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж нь аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан тухай холбогдох байгууллагын дүгнэлт;

19.3.6.эрүүл мэндийн байгууллага байгуулах үндэслэл, санхүүгийн тооцоо.

19.4.Энэ хуулийн 19.3.2-19.3.6-д заасан баримт бичигт тавих шаардлага, шалгуур үзүүлэлт, энэ хуулийн 19.5.2-т заасан үйл ажиллагаатай холбоотой төлбөрийн хэмжээ, холбогдох зардлын жишигийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

19.5.Эрүүл мэндийн байгууллагад тусгай зөвшөөрөл олгох асуудлыг дараах журмаар шийдвэрлэнэ:

19.5.1.үүсгэн байгуулагч нь энэ хуулийн 19.3-т заасан баримт бичгийг өргөдлийн хамт энэ хуулийн 19.2-т заасан байгууллагад ирүүлэх;

19.5.2.энэ хуулийн 19.2-т заасан байгууллагаас

² Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль "Төрийн мэдүүлэл" эмхтгэлийн 2001 оны 6 дугаарт нийтгэжээ.



томилгдсон ажлын комисс үүсгэн байгуулагчийн өргөдөл, холбогдох баримт бичгийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор тусгай зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ.

19.6. Энэ хуулийн 19.5.2-т заасан ажлын комиссын үйл ажиллагаатай холбогдсон тогтмол зардлыг үүсгэн байгуулагч хариуцна.

19.7. Тусгай зөвшөөрөл эзэмшигч энэ хуулийн 19.3.1-19.3.6-д заасан баримт бичигт орсон бөрчлөлт бүрийг тусгай зөвшөөрөл олгосон байгууллагад 7 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.

19.8. Тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүснэгтээ тусгай зөвшөөрөл олгосон байгууллагад хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө тавьж шийдвэрлүүлнэ.

19.9. Тусгай зөвшөөрлийн хугацааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6.3-т зааснаас гадна дор дурдсан нөхцөлийг хангасан тохиолдолд сунгана:

19.9.1. Харьяа орон нутгийн татварын байгууллагаас тодорхойлолт гаргуулсан;

19.9.2. Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн тухай харьяа орон нутгийн нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт авсан.

19.10. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд зааснаас гадна энэ хуулийн 18 дугаар зүйлд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлнэ.

19.11. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд зааснаас гадна дор дурдсан үндэслэлээр тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно:

19.11.1. Тусгай зөвшөөрлийг хуулийн хүчинтэй хугацаанд сунгуулаагүй;

19.11.2. Тусгай зөвшөөрөл авснаас хойш зургаан сарын дотор үйл ажиллагаагаа явуулж эхлээгүй.

20 дугаар зүйл. Эрүүл мэндийн байгууллагын эрх, үүрэг

20.1. Эрүүл мэндийн байгууллага дараах эрх эзэлнэ:

20.1.1. Хүн амын эрүүл мэндтэй холбогдсон асуудлыг

мэргэжлийн дээд шатны байгууллага буюу нутгийн өөрөө удирдах болон нутгийн захирагааны байгууллагад тавыж шийдвэрлүүлэх;

20.1.2.аж ахуйн нэгж, байгууллага, гэр бүл, хувь хүнд мэргэжлийн зөвлөгөө, зааварчилга егех;

20.1.3.мэргэжлийн онцлог асуудлаар төрийн болон төрийн бус байгууллага, иргэнд шаардлага тавих;

20.1.4.байгууллагын зорилго, эрх, үүрэгт харш үйлдэл хийлгэхээр шаардсан тохиолдолд тухайн тусламж, үйлчилгээг үзүүлэхээс татталзах;

20.1.5.иргэн болон байгууллагын буруутай үйлдлээс болсон осолт гэмтэл, хордлого зэрэгээс үүдэн эрүүл мэндийн байгууллагаас гарсан гэнэтийн зардлыг Иргэний хуульд нийцүүлэн буруутай этгээдээр нохон телүүлэх;

20.1.6.хууль тогтоомжид заасан бусад эрх.

20.2.Эрүүл мэндийн байгууллага дараах үүрэг хүлээн:

20.2.1.эрүүл мэндийн тухай хууль тогтоомж, мэргэжлийн дээд шатны байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захирагааны байгууллагын шийдвэр, улсын байцаагчийн шаардлагыг биелүүлэх;

20.2.2.барилга байгууламж, оношлогоо, эмчилгээний багаж, тоног төхөөрөмж болон холбогдох бусад техник хэрэгсэл нь эрүүл ахуйн болон стандартын шаардлага хангасан, эмнэлгийн ажилтны хөдөлмөрийн онцлогт тохирсон, аюулгүй ажиллагааны нехцелийг бурдуулсан байх;

20.2.3.үйл ажиллагаанд даа чанарын стандартын шаардлагыг хангах;

20.2.4.эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийг нийтэд сурталчлах;

20.2.5.хувь хүн, гэр бүл, хамт олонд эрүүл мэндийн боловсрол олгох, хүн амын дунд эрүүл мэндийт дэмжих орчныг бурдуулэх талаар бусад байгууллагатай хамтран ажиллах;

20.2.6.үйл ажиллагааныхаа тайлан, мэдээг хугацаанд нь гаргаж егех, бусад байгууллага, иргэний эрүүл мэндийн асуудлаар өөрийн

үйл ажиллагаатай холбоотой мэдээллийн хангах;

20.2.7.эмнэлгийн мэргэжилтэнд мэдлэг мэргэжилээ дээшилүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, ажилтны нийгмийн баталгааг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

20.2.8.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

21 дүгээр зүйл. Эрүүл мэндийн байгууллагын дүрэм

21.1. Эрүүл мэндийн байгууллага дүрэмтэй байна,

21.2. Терийн өмчийн эрүүл мэндийн байгууллага, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дүрмийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

21.3. Эрүүл мэндийн байгууллагын дүрэмд даравх зүйлийг тусгана:

21.3.1. байгууллагын үндсэн зорилго, чиг үүрэг;

21.3.2. удирдах бүрэлдэхүүн, түүний эрх хэмжээ;

21.3.3. санхүүжилтийн эх үүсвэр;

21.3.4. хөрөнгийн зарцуулалт.

22 дугаар зүйл. Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг магадлан итгэмжлэх

22.1. Эрүүл мэндийн байгууллага сайн дурьн үндсэн дээр өөрийн байгууллагын үйл ажиллагааг болон хүн амд үзүүлж байгаа тусламж, үйлчилгээний технологи, чанарыг үнэлүүлж, магадлан итгэмжлэл авна.

22.2. Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн терийн захирагааны байгууллага олгоно.

22.3. Энэ хуулийн 22.2-т заасан магадлан итгэмжлэх байгууллага нь эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагаа, эмнэлгийн тусламж, үйлчилгээний технологи, чанарыг орон тооны бус цинжээчдээр үнэлүүлж, дүгнэлт гаргана.

22.4. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх, шинжээч сонгон шалгаруулах, ажиллуулах журам, магадлан шинжлэх шалгуур, үйлчилгээний төлберийн хэмжээ, холбогдох зардлын жишгийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

ТАВДУГААР БҮЛЭГ

ЭРҮҮЛ МЭНДИЙН САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦОО

23 дугаар зүйл. Эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоо

23.1. Эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоо нь хүн амын эрүүл мэндийг сайкруулах, хүн амд тэгш, хүртээмжтэй, чанартай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэгдэнэ.

24 дүгээр зүйл. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилт

24.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилт нь улсын төсөв, иргэний эрүүл мэндийн даатгал, Засгийн газрын тусгай сан болон аж ахуйн нэгж, байгууллага, хамт олон, иргэний хандив, эрүүл мэндийн байгууллагын төлбөртэй тусламж, үйлчилгээ, бусад үйл ажиллагаваны орлого, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс бурдана.

24.2. Улсын төсвееес санхүүжих тусламж, үйлчилгээ үзүүлэх заавар, овчин, эмгэгийн жагсаалт, санхүүжүүлэх арга, төлбөрийн хэмжээг тогтоох журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн эрүүл мэндийн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

24.3. Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам, жагсаалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, төлбөрийн жишиг хэмжээг санхүүгийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

24.4. Эрүүл мэндийн байгууллага эрүүл мэндийн даатгалгүй иргэнд үзүүлсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээний төлбөрийг тухайн иргэнээс авна.

24.5. Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага хууль тогтоомжид нийцүүлэн нэмэлт болон төлбөртэй тусламж, үйлчилгээ үзүүлж, олсон орлогыг эрүүл мэндийн ажилтын хеделмерлэх нехцэлийг сайкруулах, нийгмийн баталгааг хангах, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах, засвар, үйлчилгээ хийхэд зарцуулах бөгөөд уг орлогыг зарцуулах үлгэрчилсон журмыг санхүүгийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

24.6. Монгол Улсын иргэний эмнэлгийн тусламж, үйлчилгээний дараах төлбөрийг тэр хариуцна:

24.6.1.жирэмсний, төрөх, төрсний даравх 45 хоногт эмнэлгийн заалтаар хийлгэсэн үзлэг, шинжилгээ, эмчилгээ /зөвхөн жирэмслэлт, төрөлттэй холбоотой шалтгаанаар/;

24.6.2.терийн өмчийн зруул мэндийн байгууллагаас хүүхдэд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээ;

24.6.3.халдварт судлалын үйлчилгээ, заавал хийх болон тархвар судлалын заалтаар хийх дархлаажуулалт, халдварт өвчний голомтын ариутгал, халдвартгүйтгэл;

24.6.4.нийгмийн зруул мэндийн тусламж, үйлчилгээ, эмнэлгийн яаралтай болон түргэн тусламж, ерх, сум, тосгоны хэмжээнд үзүүлэх болон гамшиг, нийтийг хамарсан халдварт өвчний дэгдэлтийн үеийн зруул мэндийн тусламж, үйлчилгээ;

24.6.5.аргагүй хамгаалалт, гарцаагүй байдалд хүний амь нас аврахаар яваад гэмтсэн, өвчилсон хүний эмчилгээ;

24.6.6.сурьеэ, хорт хавдар, сэтгэцийн эмгэгийн /ношийн бүлгээр/ эмчилгээ;

24.6.7.удаан хугацааны нехех эгчилгээ шаардах эмгэгийн болон хөнгөвчлөх эмчилгээний зарим эмийн зг: рдал.

24.7.Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх туслымж, үйлчилгээний жагсаалт, санхүүжүүлэх арга, төлберийн хэмжээ болон зруул мэндийн байгууллагыг сонгох журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн Иргэний зруул мэндийн даатгалын тухай хуульд⁶ заасан зруул мэндийн даатгалын удирдах дээд байгууллагын дарга, эрүүл мэндийн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Заспийн газрын гишүүд хамтран батална.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫ ЭРХ, ҮҮРЭГ, НИЙГМИЙН БАТАЛГАА

**25 дугаар зүйл.Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн
үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох**

25.1.Эмнэлгийн тусламж, үйлчилгээг мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий эмнэлгийн мэргэжилтэн үзүүлнэ.

⁶ Иргэний зруул мэндийн даатгалын тухай хууль-“Төрийн мэдрэлт” эмхтгээний 2002 оны 18 дугаарт ийнхүүжсэн.



25.2. Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл нь эмчлэх, эм барих, сувилах, эх барих гэсэн төрөлтэй байна.

25.3. Анагаах ухааны боловсрол олгох зөвшөөрөл бүхий их, дээд сургууль, коллеж төгссөн, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх шалгалтад тэнцсэн эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг дор дурдсан хугацаагаар эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно:

25.3.1. хүний их эмчид эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 2 жилийн хугацаагаар;

25.3.2. нүүр амны их эмч, уламжлалт анагаахын их эмч, хүний бага эмч, энэ хуулийн 25.3.1-д заасан хугацаанд ажилласан хүний их эмчид эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 5 жилийн хугацаагаар;

25.3.3. эм зүйч, эм найруулагчид эм барих үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 5 жилийн хугацаагаар;

25.3.4. сувилагчид сувилах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 5 жилийн хугацаагаар;

25.3.5. эх баригчид эх барих үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 5 жилийн хугацаагаар.

25.4. Анагаах ухааны боловсрол эзэмшилсэн гадаадын иргэнд Монгол Улсын нутаг дэвсгэрт эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дүгнэлтийг үндэслэн 1 хүртэл жилийн хугацаагаар эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгож болно.

25.5. Зургаан сараас дээш хугацаагаар эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүссэн энэ хуулийн 25.4-т заасан гадаадын иргэн нь мэргэжлийн шалгалтад тэнцсэн байх ба мэргэжлийн үйл ажиллагааг монгол хэл дээр явуулна.

25.6. Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, уг зөвшөөрлийг нехон олгох, хүчингүй болгох журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дангаар, холбогдох зэрдлын жишгийг санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран тогтоож мөрдүүлнэ.



26 дугаар зүйл. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг тогтоох, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгох, дахин олгох

26.1. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд эмнэлгийн мэргэжилтний болон анагаах ухааны ёс зүйн хяналтын хороо, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн дэргэд ёс зүйн салбар хороо, эрдэм шинжилгээний хүрээлэн, их, дээд сургууль, тусгай мэргэжлийн төвийн дэргэд Анагаах ухааны ёс зүйн хяналтын салбар хороо тус тус ажиллана. Ес зүйн хяналтын хороо, салбар хорооны үлгэрчилсэн дүрэм, анагаах ухааны болон эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

26.2. Энэ хуульд заасан эрүүл мэндийн талаар здлэх иргэний эрх, үүргээс гадна эмнэлгийн мэргэжилтний болон анагаах ухааны ёс зүйн хэм хэмжээтэй холбогдсон эрх, үүргийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтоож болно.

26.3. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ хуулийн 26.1-д заасан ёс зүйн хяналтын хорооны шийдвэрийг үндэслэн эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг ноцтой зөрчсөн эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 6 сараас 1 жил хүртэл хугацаагаар, мэргэжлийн алдаа гаргаж, хүний амь нас, эрүүл мэндийг хохироосон нь зохих байгууллагаар тогтоогдсон бөгөөд эрүүтийн хариуцлага хүлээлгээзргүй бол 1-3 жил хүртэлх хугацаагаар тус тус хүчингүй болгоно.

26.4. Ес зүйн салбар хороо нь эмнэлгийн мэргэжилтний болон анагаах ухааны ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн эмнэлгийн мэргэжилтэнд хууль тогтоомжийн дагуу шийтгэл ногдуулах саналыг холбогдох эрх бүхий албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлнэ.

27 дугаар зүйл. Хүний их эмчийн тангараг

27.1. Анагаах ухааны боловсрол олгох тусгай зөвшөөрөл бүхий их, дээд сургуулийг хүний их эмчийн мэргэжлээр төгссөн хүн бүр "Эмч би, эмчийн ёс зүй, төрийн хуулийг чандлан сахиж, эрдэнэт хүний амь нас, эрүүл мэндийн төлөө эрдэм чадал, энээрх сэтгэлээ харамгүй зориулахая тангараглай, тангараглай, тангараглай" гэсэн тангараг өргөнө.

27.2. Энэ хуулийн 27.1-д заасан тангараг өргөх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.



27.3. Энэ хуулийн 27.1-д заасан тангараг өргөсөн хүний их эмч нэрийн тэмдэг хэрэглэнэ.

28 дугаар зүйл. Эмнэлгийн мэргэжилтний эрх, үүрэг

28.1. Эмнэлгийн мэргэжилтэн дараах эрх эзлэн:

28.1.1. мэргэжлийн асуудлаар төрийн болон төрийн бус байгууллага, түүний удирдлага, иргэнд шаардлага тавих, зөвлөгөө өвхөн;

28.1.2. гэнэтийн евчин, осол гэмтлээс хүний амь насанд аюултай байдал бий болсон, төрөх зэрэг эмнэлгийн яаралтай тусlamж үзүүлэх шаардлагатай тохиолдопд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшилийн тээврийн хэрэгслийг дайчлан ашиглах;

28.1.3. эмнэлгийн мэргэжилтний эрх, үүрэг болон евчтөний амь насанд харш үйлдэл хийлгэхээр шаардсан тохиолдопд эмчилэх, үйлчилгээс татгалзах;

28.1.4. албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажиллах нохцелооэр хангуулах;

28.1.5. мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх, 5 жил тутамд төгсөлтийн дараах сургалтад байгууллагын зардлаар хамрагдах;

28.1.6. хууль тогтоомжид заасан бусад эрх.

28.2. Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн онцлогтой холбогдсон тодорхой эрхийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргаваны төв байгууллага тогтоож болно.

28.3. Энэ хуулийн 28.1.2-т заасан эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан зардлыг түргэн тусlamжийн үйлчилгээний тарифаар холбогдох эмнэлгийн байгууллага нехен олгоно.

28.4. Эмнэлгийн мэргэжилтэн дараах үүрэг хулээн:

28.4.1. эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг биелүүлж, хүнзэг, энээрнгүй үзлийг эрхэмлэн, мэргэжлээ хүний эрүүл мэндийн зэрэг ашиглахгүй байх;

28.4.2. гэнэтийн засаг; оссл, тайлссээ зама насад, нь аюултай байдал бий болсон иргэн, төрөх гэж байгаа эхэд энэ хуулийн

28.1.3-т зааснаас бусад тохиолдолд эмнэлгийн тусламжийг ямар ч нехцелд үзүүлэх;

28.4.3.үйл ажиллагаандав зруул мэндийн тухай хууль тогтоомж, оношлогоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх ажлын стандарт, технологи, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх удирдамжийг мөрдеж ажиллах;

28.4.4.хүн амд зруул мэндийн боловсрол олгох чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах, зруул аж төрөх ёсыг хэвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

28.4.5.өвчтөний өвчин, эмгэг болон нас барагчийн талаархи хууль тогтоомжоор хориглосноос бусад мэдээллийг холбогдох байгууллага, иргэн, өвчтөний болон нас барагчийн ар гэрийнхэнд огех;

28.4.6.мэргэжлийн ур чадвараа байнга дээшлүүлэх;

28.4.7.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

29 дүгээр зүйл.Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгаа

29.1.Эрүүл мэндийн ажилтны цалингийн тусгай сүүжиний доод жишигийг зруул мэндийн тусламж, үйлчилгээний төрөл, онцлогийг харгалzan хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

29.2.Төрийн өмчийн зруул мэндийн болон боловсролын байгууллагад 25 ба түүнээс дээш жил ажилласан эмнэлгийн мэргэжилтэн тэтгэвэрт гарахад 24 сарын, зруул мэндийн бусад ажилтан тэтгэвэрт гарахад 12 сарын, өрхийн зруул мэндийн төв, сум, тосгоны зруул мэндийн төв, сум дундын эмнэлэгт 10 ба түүнээс дээш жил ажилласан эмнэлгийн мэргэжилтэн тэтгэвэрт гарахад 36 сарын, зруул мэндийн бусад ажилтан тэтгэвэрт гарахад 18 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг тэтгэвэрт гарах үед авч байсан үндсэн цалингаас нь тооцон ажиллах байгаа байгууллагасаа авах эрхтэй.

29.3.Энэ хуулийн 29.2-т заасан нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгоход шаардагдах зардлыг тухайн байгууллагын төсөвт тусгаж байна.

29.4.Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага нь эмнэлгийн мэргэжилтэнд урамшуулал олгох, нийгмийн баталгааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх



арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

29.5.Өрхийн болон сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтэнд З жил тутамд нэг удаа б сарын, аймгийн нэгдсэн эмнэлэг, бусийн оношлогоо, эмчилгээний төвд ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтэнд 5 жил тутамд б сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтэмжийг ажиллаж байгаа байгууллагаас нь олгоно.

29.6.Эрүүл мэндийн ажилтныг жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэг, шинокшилгээнд төлбөргүй хамруулна.

29.7.Эрүүл мэндийн ажилтандаа ажилласан 5 жил тутамд нь Хөдөлмөрийн тухай хуулиар⁷ тогтоосон залжийн амралтын үндсэн болон нэмэгдэл амралт дээр нь 1 өдрийн нэмэгдэл амралт олгоно.

29.8.Сум, тосгоны эрүүл мэндийн төв, багийн эмчийн салбарт 5 ба түүнээс дээш жил ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтнийг мэргэжил дээшлүүлэх сургалтад 5 жил тутамд улсын зардлаар хамруулна.

30 дугаар зүйл. Эрүүл мэндийн ажилтандаа олгох нэмэгдэл хөлс, нохон төлбөр

30.1.Олон улсын хол хориот халдварт өвчний голомтод болон гамшигийн үед дайчилгаагаар ажилласан эрүүл мэндийн ажилтандаа тухайн дайчилгааг зохион байгуулсан газар 1 сарын дотор ажилласан хугацааны цалин хөлсийг нь 3 дахин нэмэгдүүлж олгоно.

30.2.Эрүүл мэндийн ажилтан нь олон улсын хол хориот халдварт өвчний голомтод ажиллаж халдвэр авсны улмаас болон ажил үүргээ гүйцэтгэх үедээ амь насаа алдвал ар гэрт нь түүний 5 жилийн үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгуй менгэн туслаамж олгох бөгөөд ажил үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан бие махбодид нь гэмтэл учруулсан буюу эрүүл мэндийг нь бусад хэлбэрээр хохироосноос хөдөлмөрийн чадвараа түр алдсан, тахир дутуу болсон тохиолдолд тэтгэвэр, тэтгэмж, авч байсан цалингийн зөвүүт хөдөлмөрийн чадвар түр алдсан, тахир дутуугийн тэтгэмж авч байсан нийт хугацаанд олгоно.

30.3.Олон улсын хол хориот халдварт өвчний голомтод дайчилгдан ажилласан иргэнд нохон төлбөр, цалин хөлсний зоруут эрүүл мэндийн ажилтны ногэн адил олгоно.

⁷ Хөдөлмөрийн тухай хууль – “Төрийн мэдээлэл” эмчилгээний 1999 оны 25 дугаартийн тогтолцоогийн.

30.4. Энэ хуулийн 30.3-т заасан иргэн тогтмол ажил эрхэлдэгтүй бол цалин хэлсийг тухайн үед мөрдөгдөж байгаа хөдөлмөрийн хэлсний доод хэмжээгээр тооцю.

30.5. Эрүүл мэндийн ажилтанд хууль тогтоомжид заасны дагуу цалин хэлсний нэмэгдэл, мөнгөн урамшуулалт олгох бөгөөд тэдгээрийн төрөл, хэмжээ, олгох журмыг Засгийн газар батална.

ДОЛДУГААР БҮЛЭГ ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ХЯНАЛТ

31 дүгээр зүйл. Эмнэлгийн мэргэжилтний мэргэшүүлэх болон давтан сургалт

31.1. Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалт явуулах, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох, мэргэжлийн зэрэг олгох журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн терийн захиргааны төв байгууллага боловсролын асуудал эрхэлсэн терийн захиргааны төв байгууллагатай, тадгээртэй холбоотой үйлчилгээний төлбөрийн хэмжээ, зардлын жишигийг санкүүтийн асуудал эрхэлсэн терийн захиргааны төв байгууллагатай тус тус хамтран тогтоож мөрдүүлнэ.

31.2. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн терийн захиргааны төв байгууллагын дэргэд эмнэлгийн мэргэжлийн төгсөлтийн даралх мэргэшүүлэх болон давтан сургалт явуулах, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох, мэргэжлийн зэрэг олгох асуудал хариуцсан орон түүхийн бу: зөвлөл ажиллуулж болох бөгөөд Зөвлөгийн бүрэлдэхүүн, дүрүүдийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

32 дугаар зүйл. Эрүүл мэндийн байгууллагын тусгай эрх

32.1. Эхийн хэвлэй дэх ураг удамшын болон бие эрхтний гаж хөгжилтэй болох нь тогтоогдсон, эсхүл тухайн жирэмслэлт нь эх, ургийн амь насанд ноцтой аюул учруулж болох онцгой нөхцөлд жирэмсэн эх, шавардлагатай гэж үзэл түүний нөхөр буюу гэр бүлгийн гишүүнээс бичгээр зөвшөөрөл авч, жирэмслэлтийг эмнэлгийн аргаар тасалж болно.

32.2. Үр хөндөх ажилбарыг эх барих, эмэгтэйнүүдийн тусламж, үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий магадлан итгэмжлэгдсэн эмнэлэгт тухайн мэргэжлээр үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй их эмч гүйцэтгэнэ.

32.3. Үр хөндөх ажилбар гүйцэтгэх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

32.4. Нийгэмд аюул учруулж болзошгүй зарим өвчтэй хүмүүсийг захиргааны журмаар албадан эмчлэх асуудлыг хуулиар зохицуулна.

33 дугаар зүйл. Эмгэг судлалын шинжилгээ хийх

33.1. Нас барагчийн цопцост үхлийн шалтгаан болон өвчиний онош зөв тогтоогдсон эсэхийг тодорхойлох зорилгоор эмгэг судлалын шинжилгээ хийнз.

33.2. Энэ хуулийн 33.1-д заасан эмгэг судлалын шинжилгээ хийх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

34 дүгээр зүйл. Донорын эд, эрхтэн авах, тэдгээрийг эмчилгээнд хэрэглэх, цус, цусан бүтээгдэхүүнийг бэлтгэх, улсын хилээр нэвтрүүлэх

34.1. Донорын эд, эрхтэн авах, тэдгээрийг эмчилгээнд хэрэглэх, цус, цусан бүтээгдэхүүнийг бэлтгэх, импортлох, экспортлох асуудлыг хуулиар зохицуулна.

35 дугаар зүйл. Халдварт өвчинеес урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх

35.1. Халдварт өвчинеес урьдчилан сэргийлэх, өвчин гарсан тохиолдолд тараахгүй байх, таслан зогсоох, тусгаарлах, хел хорио тогтоох журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

35.2. Олон улсын хел хориот болон байгалийн голомтот халдварт өвчинеес урьдчилан сэргийлэх, идэвхжэсэн голомтыг цомхочтох арга хэмжээг нутгийн захиргааны байгууллага холбогдох байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.

35.3. Бусдын эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй халдварт өвчтэй хүн, нян тээгчийг эмнэлэгт тусгаарлан эмчлэх, шаардлагатай үед тэдгээрийн хавьтлыг тусгаарлан хел хорио тогтооно.

35.4. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр өвчин үүсгэгч нян, түүний хорыг лабораторийн болон үйлдвэрлэлийн зориулалтаар естеворлэх, үргүүлэх, хадгалах, новцлех, тээвэрлэх, худалдах, улсын хилээр гаргах, оруулахыг хориглоно.

35.5. Халдварт өвчинтэй тэмцэх нийгмийн эрүүл мэндийн арга



хэмжээг энэ хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжоор зохицуулна.

35.6.Хагдварт өвчинеес урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол Улсын иргэн, тус улсад байнга буюу түр оршин суугаа гадавадын иргэн, харьяалалгүй хүнийг дархлаажуулалтад хамруулна.

35.7.Дархлаажуулалтыг зохион байгуулах асуудлыг хуулиар зохицуулна.

36 дугаар зүйл. Оношлогоо, эмчилгээнд хэрэглэх арга

36.1.Эрүүл мэндийн байгууллага нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагас зөвшөөрсөн аргаар оношлох, эмчлэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулна.

36.2.Иргэнд нарийн төвөгтэй оношлогоо, мэс засал хийх, түүнийг анагаах ухааны судалгаа, туршилгад оролцуулах бол тухайн иргэнээс, 18 насанд хүрээгүй хүүхэд, сэтгэцийн өвчиний улмаас эрх зүйн чадамжгүй болох нь тогтоогдсон өвчтөний тухайд хууль ёсны төлөвлөгөө /эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч/-вес нь бичгээр зөвшөөрөл авна.

36.3.Нарийн төвөгтэй оношлогооны арга хэрэглэх, мэс засал хийх хугацааг хойшлуулах нь өвчтөний амь насанд аюул учруулж болзошгүй тохиолдолд асуудлыг эмч, эмнэлгийн байгууллага шууд шийдвэргүй болно.

37 дугаар зүйл.Оношлогоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх шинэ аргыг турших, бүртгэх, нэвтрүүлэх

37.1.Анагаах ухааны салбарт оношлогоо, эмчилгээний шинэ арга турших, нэвтрүүлэх, бүртгэх, баталгаажуулах, мэдээлэх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

37.2.Өвчнийг оношлох, эмчлэх, өвчинеес урьдчилан сэргийлэх шинэ арга, технологийг эмнэл зүйн туршилт явуулсны дараа эмнэлгийн практикт хэрэглэн.

37.3.Эмнэл зүйн туршилт явуулах, судалгаа, шинжилгээний зорилгоор хүний цус, цусан бүтээгдэхүүн, биологийн шингэн, эд, эрхтэн авах, хэрэглэх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

37.4.Эмчилгээний зориулалтаар шинээр гарч байгаа болон

нанотехнологийн бүтээгдэхүүний судалгаа явуулах, практикт нэвтрүүлэх үйл ажиллагааг зохицуулах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн холбогдох Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.

38 дугаэр зүйл. Эмнэлгийн магадлагаа гаргах

38.1. Эмч, эмнэлгийн байгууллага дор дурдсан асуудлаар магадлагаа гаргана:

38.1.1. Монгол Улсын иргэн, тус улсад байнга буюу туроршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн овчлох, осол, гэмтэлд ортех, нас барах, төрөх, хиймэл эрхтэн хийлгэх, сувилтуулах, хел хоригдох, евчтэн асрах;

38.1.2. хөдөлмөрийн чадварла хагас болон бүрэн алдах;

38.1.3. цогцост задлан шинжилгээ хийсэн тухай дүтнэлт гаргах;

38.1.4. эрүүл мэндийн холбогдолтой бусад асуудлаар.

39 дүгээр зүйл. Сэтгэцийн өвчтэй хүнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ

39.1. Сэтгэцийн өвчтэй хүнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх асуудлыг хуулиар зохицуулна.

40 дүгээр зүйл. Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, протез үйлдвэрлэх, худалдах, импортлох, ханганд нийлүүлэх

40.1. Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, протез үйлдвэрлэх, худалдах, импортлох, ханганд нийлүүлэх үйл ажиллагааг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд эрхэлнэ.

40.2. Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, протез үйлдвэрлэх, худалдах, импортлох, ханганд нийлүүлэх, ашиглахад тухайн бүтээгдэхүүний техникийн болон чанарын баталгаажуулалтын баримт бичгийг хавсаргасан байна.

40.3. Энэ хуулийн 40.2-т заасан баримт бичигт тухайн



бүтээгдэхүүний материалын бүтэц, чанар, техникийн болон бусад үзүүлэлт, баталгаат хугацаа, засвар, үйлчилгээ хийх болон дагалдах хэрэгсэл, урвалж бодисоор хангах нехцелийг тусгасан байна.

41 дүгээр зүйл. Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдвартгүйжүүлэх бодис импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх, худалдах

41.1. Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдвартгүйжүүлэх бодис импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх, худалдах үйл ажиллагааг эрүүл мэндийн асуудал эрхэлсон терийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд эрхэлнэ.

41.2. Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдвартгүйжүүлэх бодисыг улсын бүртгэлд бүртгэх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

42 дугаар зүйл. Эрүүл мэндийн мэргэжлийн хяналт

42.1. Эрүүл мэндийн үйл ажиллагаанд мэргэжлийн хяналт, шинжилгээ хийх, шалгах, дүгнэх, эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар шалгалт хийх, шалгалтын дүнг мэдээлэх, илэрсэн зөрчил, дутагдлыг буруутай албан тушаалтнаар арилгуулах, хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд энэ хуулийн дагуу захиргааны хариуцлага хулзэлгэх чиг үүргийг эрүүл мэндийн хяналтын асуудал эрхэлсон терийн захиргааны байгууллага болон эрүүл мэндийн байгууллагын дотоод хяналт хариуцсан алба хэрэгжүүлнэ.

42.2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдалд дотоодын хяналт тавих үүрэг бүхий албаны дарга, ажилтанд мэргэжлийн хяналтын байцаагчийн эрх олгож болно.

42.3. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдалд дотоодын хяналт тавих албаны дүрмийг эрүүл мэндийн болон мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

42.4. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн терийн захиргааны төв байгууллагын дэргэд эрүүл мэндийн чанарын хяналтын орон тооны бус зөвлөл ажиллуулж болох бөгөөд зөвлөлийн дуром, бүрэлдэхүүнийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

НАЙМДУГААР БҮЛЭГ
ИРГЭНИЙ ЭРХ, ҮҮРЭГ, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА,
ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОО

43 дугаар зүйл. Иргэний эрх, үүрэг

43.1. Иргэн эрүүл мэндээ хамгаалах талаар дараах эрх эдэлнэ:

43.1.1. эмч, эрүүл мэндийн байгууллагаас тусламж, үйлчилгээ авах;

43.1.2. ерхийн эмчээ сонгон бүртгүүлэх;

43.1.3. вэрийн эрүүл мэндийн тухай мэдээллийг эмч, эрүүл мэндийн байгууллагаас авах;

43.1.4. халдварт евчноос бусад тохиолдолд эмчилгээ, оношлогоо, шинжилгээ хийлгэхээс татгалзах;

43.1.5. хүний эрүүл мэндэд харш үйл ажиллагва явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэний талаар холбогдох байгууллагад оргедел, гомдол гаргах;

43.1.6. эрүүл мэндийн боловсролоод дээшилүүлэх зорилгоор эрүүл мэндийн байгууллага, ажилтнаас мэдээлэл авах;

43.1.7. хуулийн хүрээнд вэрийн эрүүл мэндтэй холбоотой мэдээллийн нууцыг хадгалааах.

43.2. Иргэн эрүүл мэндээ хамгаалах талаар дараах үүрэг хүлээнэ:

43.2.1. эрүүл мэндийн боловсрол эзэмших, хэвшүүлэх, амьдрал ахуйн таатай нехцөлийг бурдуулэх;

43.2.2. хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар зохиож байгаа ажилд оролцох;

43.2.3. халдварт евчин тархаахас сэргийлж, хөл хорионы дэглэмийг сахиж мордех;

43.2.4. хүний эрүүл мэнд болон нийгэмд аюул бүхий эсчүү, цердигого, гостя, гэмтээр, сүнчны сэргэг уүчин эмчийн талаар элүүл мэндийн байгууллагад цаг тухайд нь мэдээлэх;

43.2.5.хүний эрүүл мэндэд серег нелее үзүүлэх эрсдэлт зал үйлээс татгалзах, сэргийлэх, эрүүл мэндэд серег нелее үзүүлэх үйлдлийг таслан зогсоох талаарх эрүүл мэндийн байгууллагын шаардлагыг биелүүлэх;

43.2.6.халдварт өвчний үзлэг, шинжилгээнд өөрийн санаачилгаар болон эмч, эмнэлгийн байгууллагын шаардлагаар орох;

43.2.7.эмнэлгийн яаралтай тусламжаас бусад эмнэлгийн тусламжийг ерх, сум, тосгон, сум дундын эрүүл мэндийн байгууллагын ерөнхий мэргэжлийн эмчийн илгээх бичгээр авах;

43.2.8.эрүүл мэндийн ажилтныг ажил үүргээ гүйцэтгэж байхад саад учруулахгүй, нэр хүнд, бие махбодид нь халдахгүй байх;

43.2.9.эрүүл мэндийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй, эрүүл мэндийн байгууллагын нэр хүндийг унагвах зорилго бүхий ташаа мэдээлэл өгөхгүй байх.

44 дүгээр зүйл. Эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаарх аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг

44.1.Эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллага дараах үүрэг хүлээнэ:

44.1.1.эрүүл мэндийн тухай хууль тогтоомж, Засгийн газар, нутгийн захиргааны болон нутгийн оюреө удирдах байгууллагын шийдвэр, эрүүл мэндийн байгууллага, мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн шаардлагыг биелүүлэх;

44.1.2.өөрийн байгууллагын ажилтны эрүүл мэндийг дэмжих, өвчин змэгээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох арга хэмжээг эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийн дагуу зохион байгуулах;

44.1.3.хеделмер, эрүүл ахуйн нехцелийг эрүүлжүүлэх, хеделмерийн чадвар алдалтыг бууруулах арга хэмжээ авч, аливаа өвчин, ялангуяа хордлого, халдварт, осол, гэмтэл, мэргэжлээс шалтгаалах өвчинеос урьдчилан сэргийлэх, эрх бүхий байгууллагавас баталсан эрүүл ахуйн стандарт, хэм хэмжээ, журмыг чанд сахин биелүүлэх;

44.1.4.хүний эрүүл мэндэд сергеөр нелөөвлж болзошгүй үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага уг нелөөвлээс сэргийлэн хамгаалах арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг жил бүр



төсөв, төлөвлөгөөндөө тусгаж, үйлдвэрлэл, үйлчилгээний зруул ахуй, технологийн нохцол, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд даа зарцуулах;

44.1.5.хүний зруул мэнд болон нийгэмд аюул учруулах халдварт өөчин, хордлого, осол, гэмтэл гаргахгүй байх нохцол бүрдүүлж, аюулгүй байдлыг хангасан ажил, үйлчилгээ явуулах.

45 дугаар зүйл.Зруул мэндийг хамгаалах, дэмжихэд төрийн бус байгууллагын оролцоо

45.1.Зруул мэндийг хамгаалах, дэмжих талаар төрийн бус байгууллага дараах үйл ажиллагаа явуулж болно:

45.1.1.зруул мэндийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

45.1.2.зруул мэндийг дэмжих, хамгаалах үйл ажиллагаанд хамт олон, иргэнийг оролцуулах, зруул зан үйл төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгаа, зруул мэндийн боловсрол олгох ажлыг дангаар болон бусад байгууллагатай хамтран зохион байгуулах.

45.2.Энэ хуулийн 9.1.3, 9.1.4, 9.1.8, 12.1.2, 19.1, 19.2, 19.10, 19.11, 31.1-д заасан үйл ажиллагаа явуулахдаа мэргэжлийн нийгэмлэг, холбооны саналыг харгалзан үзэж болно.

**ЕСДҮГЭЭР БҮЛЭГ
БУСАД ЗҮЙЛ**

46 дугаар зүйл.Зруул мэндийн тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

46.1.Зруул мэндийн тухай хууль тогтоомж зөрчсен гэм буруутай этгээдэд зруулийн хариуцлага хүлээлгээргүй бол эрх бүхий улсын байцаагч, шүүгч зөрчлийн шинж байдлыг харгалзан дараах захиргааны хариуцлага хүлээлгэнэ:

46.1.1.зөвшөөрөлгүйгээр буюу зөвшөөрөлд засныг зөрчиж, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа явуулсан бол хууль бусаар опсон орлогыг хурааж, зөрчил гаргасан этгээдийг хедепмерийн хөлөнний доод хэмжээг 5-10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;



46.1.2.энэ хуулийн 13.4.3., 13.4.4-г зөрчсөн бол хеделмерийн хелсний доод хэмжээг 10-25 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

46.1.3.энэ хуулийн 20.2.1., 20.2.2., 36.1., 44.1.1., 44.1.3., 44.1.5-ыг зөрчсөн албан тушаалтныг хеделмерийн хелсний доод хэмжээг 10-25 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг хеделмерийн хелсний доод хэмжээг 25-50 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

46.1.4.энэ хуулийн 28.4.1-28.4.3., 32.2-г зөрчсөн бол зөрчил гаргасан этгээдийг хеделмерийн хелсний доод хэмжээг 10-25 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

46.1.5.энэ хуулийн 35.3., 35.4-г зөрчсөн иргэнийг хеделмерийн хелсний доод хэмжээг 5-10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг хеделмерийн хелсний доод хэмжээг 10-25 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг хеделмерийн хелсний доод хэмжээг 25-50 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

46.1.6.энэ хуулийн 36.2., 37.2-г зөрчсөн бол иргэнийг хеделмерийн хелсний доод хэмжээг 5-10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг хеделмерийн хелсний доод хэмжээг 10-25 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг хеделмерийн хелсний доод хэмжээг 25-50 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

46.1.7.энэ хуулийн 40.1., 41.1-г зөрчсөн бол хууль бусаар опсон орлого, бусад эд зүйлийг хурааж, зөрчил гаргасан иргэнийг хеделмерийн хелсний доод хэмжээг 5-10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг хеделмерийн хелсний доод хэмжээг 10-25 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг хеделмерийн хелсний доод хэмжээг 25-50 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

46.1.8.энэ хуулийн 43.2.3., 43.2.4., 43.2.5., 43.2.8., 43.2.9-г зөрчсөн бол иргэнийг хеделмерийн хелсний доод хэмжээг 5-10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.

46.2. Эрүүл мэндийн тухай хууль тогтоомж зөрчсөн иргэн, хуулийн этгээдийн хууль бус үйлдлийг нуух, авлига авах, хуулиар хамгаалсан төрийн болон байгууллага, хувь хүний нууц задруулах зэргээр хуулиар хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн албан тушаалтан, улсын байцаагчид хууль тогтоомжид заасны дагуу сахилгын, захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээлгэнз.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 05 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
 хот

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТӨОЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1998 оны 5 дугаар сарын 07-ны өдөр баталсан Эрүүл мэндийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Эрүүл мэндийн тухай /Шинчилсэн найруулага/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мерднө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 05 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
 хот

АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд дор дурдсан агуулгатай 15 дугаар зүйлийн 15.12.11 дэх заалт нэмсүгэй:

"15.12.11. улсын хэмжээний болон гадаадын хөрөнгө оруулалттай эрүүл мэндийн байгууллага мэргжлийн үйл ажиллагаа явуулах."



2 дугаар зүйл. Энэ хуулийг Зруул мэндийн тухай /Шинчилсэн нийтуулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2011 оны 05 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар 97

Улаанбаатар
хот

Элчин сайдыг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дахь хэсгийн 5, "Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 14 дүгээр зүйлийн 3, "Дипломат албаны тухай" хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Кипр Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Цэрэндоржийн Ганхуягийг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 3 дугаар
сарын 22-ны өдөр

Дугаар 94

Улаанбаатар
хот

Зарим байгууллагын байршлыг тогтоох тухай

Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын II байрны А корпуст Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамыг, Б корпуст Үндэсний хөгжил, шинэчлэлийн хороог, В корпуст Эрдэс баялаг, эрчим хүчний яамыг, мен корпусын Төрийн сан байрлаж байсан хэсэгт Хөгжлийн банийг, Г корпуст Байгаль орчин, аялал жуулчлалын яамыг тус яаман дээр хэрэгжүүлж байгаа төслийн нэгжүүдийн хамт, Д корпуст Сангийн яамыг тус яаман дээр хэрэгжүүлж байгаа төслийн



нэгжүүдийн хамт, нийслэлийн Сүхбаатар дүүргийн VIII хороо, Их тойрууд байрлах Гаалийн еренхий газрын хуучин байранд Цөмийн энергийн газрыг цөмийн болон цацрагийн хяналтын газруудтай нь хамт, нийслэлийн Баянгол дүүргийн IV хороолол, Амарсанаагийн гудамжинд байрлах Харилцаа холбооны зохицуулах хорооны хуучин байранд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрыг тус тус байришуулсугай.

2. Засгийн газрын III, XI байранд чөлөөлгөдөвж байгаа орооний хуваарийг хавсралт ёсоор баталсугай.

3. Сангийн яамны шинэ байр (Д.корпус)-ыг Засгийн газрын II байрны харьянд төрийн өмчид бүртгэн авахыг Төрийн өмчийн хороо (Д.Сугар)-нд даалгасугай.

4. Цөмийн энергийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Мэргэжлийн хяналтын еренхий газрын төв лабораторийн байрны 8 орлог Мэргэжлийн хяналтын еренхий газарт, нийслэлийн Баянгол дүүргийн IV хороолол, Амарсанаагийн гудамжинд байрлах Харилцаа холбооны зохицуулах хорооны хуучин байрыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт, нийслэлийн Сүхбаатар дүүргийн VIII хороо, Их тойрууд байрлах Гавлийн еренхий газрын хуучин байрыг Цөмийн энергийн газарт тус тус балансаас балансад шилжүүлэхийг Төрийн өмчийн хороо (Д.Сугар)-нд зөвшөөрсгүй.

5. Засгийн газрын II байрны Гкорпусын төрийн тусгай хамгаалалтын ног цэгийг Сангийн яамны шинэ байр буюу Засгийн газрын II байрны Д корпуст шилжүүлж, төрийн тусгай хамгаалалтын бусад цэгийг мөн байрны А, Б, В, Г корпуст үргэлжлүүлэн ажиллуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Хүрэлбаатар, Тагнуулын еренхий газрын дарга Р.Болд нарт зөвшөөрсгүй.

6. Зарим яам, агентлагийн байршилыг шинчлэн тогтоосны дагуу Засгийн газрын байруудын харуул хамгаалалт, үйлчилгээ, төсөв зардалтай холбостой асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шайдвэрлэх арга хэмжээ авч, цаашид зардал хэмнэх зорилгоор яам, Засгийн газрын агентлагийн болон төрийн өмчийт байруудын харьялал, стандарт, хангамж, үйлчилгээний талаар судалгаа, тооцоо хийж Засгийн газарт танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Хүрэлбаатарт даалгасугай.

7. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Зарим агентлагийн байршилыг тогтоох тухай" Засгийн газрын 2009 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 77 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн "Үндэсний хөгжил,

шинэцгэлийн хороог Засгийн газрын II байрны А корпуст, Цөмийн энергийн газар" гэсэн хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Ч.ХҮРЭЛБААТАР

Засгийн газрын 2011 оны 94 дүгээр
тогтоолын хавсралт

**ЗАСГИЙН ГАЗРЫН III, XI БАЙРНЫ ЧӨЛӨӨЛӨГДӨХ
ӨРӨӨНИЙ ХУВААРЬ**

№	Засгийн газрын байр	Чөлөөлгөх өрөө	Эзэмшүүлэх байгууллага	Хувьшигах өрөө
1	III байр	8 /төслийн нэгжүүд/	Боловсрол, соёл, шинжлэх указын яам Үндэсний статистикийн хороо	4 /1 өрөө нь дамждаг/ 4
			Мэргэжлийн боловсрол, сургалтын газар Мал эмнэлгэг, уржлийн газар "Алтанбулаг" худалдааны чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар	4 2 2 2
2	XI байр	15 /Цөмийн энергийн газар/	Замын-Үүд хилдийн 300тг. Дорноговь аймгийн Замын-Үүд сум болон "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийг хариуцсан Засгийн газрын бурэн эрхт төлөөлгөчийн ажлын алба Өмнөговь аймаг дахь хилдийн босмын үйл ажиллагааг зохицуулах Засгийн газрын бурэн эрхт төлөөлгөч биеөөд бoomтын захиргааны даргын ажлын алба Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс	2 2 1

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 3 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 95

Улаанбаатар
хот

Зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Газар хедлэлтийн гамшигийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангахад мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааг улсын хэмжээнд уялдуулан зохицуулж, нэгдсэн удирдлагаар хангах үүрэг бүхий байнгын ажиллагаатай зөвлөлийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, "Газар хедлэлтийн гамшигаас хамгалах үндэсний чадавхийг бэхжүүлэх төлөвлөгөө"-г 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Байнгын ажиллагаатай зөвлөлийн ажиллах журмыг батлан, мөрдөж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд биеөд Зөвлөлийн дарга М.Энхболдод үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАТБОЛД

МОНГОЛ УЛСЫН
ШАДАР САЙД

М.ЭНХБОЛД

Засгийн газрын 2011 оны 95 дугаар
тогтооплын 1 дүгээр хавсралт

БАЙНГЫН АЖИЛЛАГААТАЙ ЗӨВЛӨЛИЙН
БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга - Монгол Улсын Шадар сайд

Орлогч дарга: - Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд;

-Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга.

Гишүүд: -Байгаль орчин, аялал жуулчлалын сайд;

-Батлан хамгаалахын сайд;

-Болдасрол, соёл, шинжлэх ухааны сайд;

-Эрдэс баялаг, эрчим хүчний сайд;

- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд;
 - Эрүүл мэндийн сайд;
 - Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч;
 - Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Онцгой байдлын ерөнхий газрын дарга;
 - Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга;
 - ШАУА-ийн Одон орон, геофизик судалгааны төвийн захирал;
 - Шадар сайдын зөвлөх.
- Нарийн бичгийн дарга:
- Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны ахлах референт;
 - Онцгой байдлын ерөнхий газрын Гами итгэй тэмцэх газрын дарга.

Засгийн газрын 2011 оны 95 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

**ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ
/НДЭСНИЙ ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ
ТЕЛӨВЛӨГӨӨ**

№/д	Ажил, чиглэл	Хугацаа /ж/ноор/	Хариуцах байгууллага
1	Нийслэлийн газар хөдлөлтийн бичил мужлалын зургийг шиночлон боловсруулах, шаардлагдах тоног төхөөрөмж авах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх	2011-2012	НЭДТГ, ШАУА
2	Багануур, Багахангай, Налайх дүүргийн газар хөдлөлтийн бичил мужлалын зураг хийлгэх	2011	ШАУА, НЭДТГ



3	Барилга газар хөдлөлтийн чичирхийлийг тэсвэрлэх байдал, чанарыг тодорхойлоход шаардагдах багаж, технореможийг нэмэгдүүлж нийслэлийн нийт барилгыг паспортжуулж дуусгах	2011-2013	НЭДТГ, МХЕГ
4	Нийслэлийн орон сууц олон нийт, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтын барилга байгууламжийн мэдээллийн сан байгуулах	2011-2012	НЭДТГ
5	Газар хөдлөлтийн эрсдэл бүхий хот суурингийн орон сууц олон нийт, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтын барилга байгууламжийн мэдээллийн сан байгуулах	2011-2013	Аймгийн ЗДТГ
6	Газар хөдлөлтийн мужлалын зураг, паспортжуулалтын дунг үндэслэн хуучин барилгыг буулгаж, шиночлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах	2011-2012	НЭДТГ
7	Газар хөдлөлтийн талаар үндсэн мэдлэг ойлголт өгөх, гамшигийн үед өөрийгөө болон бусдыг хамгаалах чадвартай болгох чиглэлээр хичээлийн садэв боловсруулж, ерөнхий боловсролын сургууль, цэцэрэлгийн сургалтын хетелбөрт тусган хэрэгжүүлах	2012 оны хичээлийн жилийн эхлэх	БСШЯ, ОБЕГ
8	Улсын хэмжээнд газар хөдлөлтийн гамшигас хамгаалах команд-штабын сургуулийг 3-4 аймагт, гамшигас хамгаалах юж бурэн сургуулийг 1-3 аймагт зохион байгуулах	Жил бүр	ОБЕГ, НЭДТГ, Аймгийн ЗДТГ
9	Иргэдийг болзошгүй газар хөдлөлтийн аюулаас өөрийгөө болон бусдыг аврах арга ажиллагаанд дадлагажуулах сургалтыг зохион байгуулах	Жил бүр	ОБЕГ
10	Нийслэл орчмын 300 км тойрогт болж буй газар хөдлөлтийн идрэвхийлтэд үнэлгээ өгч, газар хөдлөлтийн идэвхтэй хагарлууд дээр нарийвчилсан судалгааг эрчимжүүлах, аюул, хор хөнөөлийн хэмжээг тооцоопон тогтоох замаар нийслэл орчмын суурьшлын шинэ бүс, тэр болон захиргааны байгууллага онцгой нахцанд ажиллах хотын гадна бэлгэлтэх узүүрэлтийн байраны байршилыг тогтоох	2011-2012	ШУА, НЭДТГ, ОБЕГ

11.	Хүнтэй газар хөдлөлт болсон улс орны газар хөдлөлтийн гамшгийн сургамжийг судалж үйл ажиллагаанд хэрэгжүүлэх	2011-2012	Байнгын ажиллагаатай зөвлөл
12.	Байнгын ажиллагаатай зөвлөлтийн үйл ажиллагаанд шаардлагдах хөрөнгийг улсын төсөвт тусгах	2011	Байнгын ажиллагаатай зөвлөл
13.	"Хотыг дахин хөгжүүлэх тухай хууль"-ийн төсөлд газар хөдлөлтийн гамшгас хамгаалах, агаарын бохирдлыг бууруулах, хэт төвлөрлийг сааруулах, суурышлын шинэ бус байгуулак, дэд бүтцийг байгуулах асуудлыг тусган боловсруулах	2011	ЗТБХБЯ, НЭДТГ
14.	Хямралт байдлын үенний талаархи хуулийн төсөл боловсруулах	2011-2012	ЕТГ, УАБЗ, ОБЕГ
15.	Нурах аюултай хуучин барилгүүдиг мэргэжлийн байгууллагуудын дүгнэлтийг үндэслэн үе шаттайгаар буулгах, дахин шинээр барилгажуулах ажлыг зохион байгуулах хууль эрх зүйн орчныг бурдуулж	2011-2012	ЗТБХБЯ, НЭДТГ
16.	Барилга барих стандартын нөхцөл шаардлагыг шинэчлэн сайжруулах, олон улсын жишигийн дагуу төр-хувийн хэвшилийн зохистой харьцаа бүхий жаналтыг бий болгох	2011-2014	ЗТБХБЯ, МХЕГ
17.	Болзошгүй гамшгийн үед 100.0 мянгаас доошгүй хүн амын 1 сарын хэрэгцэг хангах гамшгийн неөөц бурдуулэх, тэдгээрийг хадгалах агуулах, сав, тоног төхөөрөмжийг худалдан авах хөрөнгийн асуудлыг Монгол Улсын 2011 оны төсөлийн тухай хуульд номэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусган шийдвэрлэх	2011	СЯ, НЭДТГ, ОБЕГ
18.	Нийслэл хотыг аюул, эрсдэл багатай бус нутагт нүүлгэн шилжүүлэх тооцоо, судалгааг хийх	2011-2013	НЭДТГ, ШУА
19.	Газар хөдлөлтийн чиглэлээр ажиллах мэргэжилтэй боловсон хүчин болтгэх, сургах, мэргэшүүлэхэд шаардлагдах хөрөнгийг шийдвэрлэх	2011	ОБЕГ, БСШУЯ, СЯ

20	Томоохон хот суурингийн газар хадлалтийн бичил мужалын зургийг хийж гүйцэтгэх	2013 оноос	ШУА, Аймгийн ЗДТГ
21	Учирч болох аюулаас сэромжуулэх "Амжиж анхааруулах систем" байгуулах төслийг боловсруулан хэрэгжүүлэх	2011-2013	ШУА, ОБЕГ
22	Дундговь, Салангэ, Баянхонгор аймгуудад газар хадлалт бүртгэх байнгын станцуудыг шинээр байгуулах хөрөнгийн эх үүсвэрийг Монгол Улсын 2011 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусган шийдвэрлэх	2011	БСШУЯ
23	Гамшигийн үед цргийн нэгдсэн эмнэлгийг өргөтгэх, гамшигт нэрвэгдсэн 5-10 мянган хүний хулээн авах хүчин чадалтай эмнэлгийн тусламж, эмчилгээ узуулэх хээрийн эмнэлэг дэлгэн ажиллуулах төсөл боловсруулах	2012-2013	БХЯ, СЯ, ОБЕГ
24	Эрэлч нохойн алба байгуулж, холбогдох зардлыг шийдвэрлэх	2011-2012	ОБЕГ, СЯ
25	Нийспойлд болзошгүй гамшигийн үед ашиглах 4 ширхэг утсаардаг гүүр авах, иргэдэд газар хадлалтийн чичирхийлэл мэдрүүлэх сургалтын автомашин худалдан авах, түүний хөрөнгийн асуудлыг тус тус шийдвэрлэх	2011-2012	НЭДТГ, СЯ, ОБЕГ
26	Нийтийг хамарсан гамшигийн үед ард иргэдийг цус, цусан бутээгдэхүүнээр найдвартай хангах, неецийг бурдуулэх, орчин үеийн шаардлага, аюулгүй байдлыг хангасан газар хадлалтад тэсвэртэй цусны шинэ төвийг байгуулах	2011-2012	ЭМЯ, СЯ, ОБЕГ, НЭДТГ
27	Ховд, Эвэрхангай, Орхон, Дорнод аймаг дахь бусийн оношилгоо, эмчилгээний төв, Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлгийн дэргэдэх цусны банкийг өргөтгэх, Сүхбаатар, Хэнтий, Төв аймгийн нэгдсэн эмнэлгийн дэргэдэх цусны банкийг үндсэн тоног төхөөрөмжөөр хангах хөрөнгийн эх үүсвэрийг 2011-2012 оны төсөвт тусган санкхүүжүүлэх	2011-2012	ЭМЯ, СЯ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 3 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар 98

Улаанбаатар
 хот

Монгол Улсын иргэнд "Эрдэнэс Тавантолгой" компанийн хувьцааг эзэмшүүлэх тухай

Хүний хөгжил сангийн тухай хуулийн 15.1, Төрийн болон орон нутгийн емчийн тухай хуулийн 9.1, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн "Нэг"-ийн 17, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 8.3.7, Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Эрдэнэс Тавантолгой" компанийн нийт хувьцааны 10 хувийг 2011 оны 3 дугаар сарын 31-ний өдөр болон түүнээсөмнө тэрсен, иргэний шинэчилсэн бүртгэлд бүртгүүлсэн Монгол Улсын иргэнд эзэмшүүлсүгэй.

2. Хувьцаа эзэмших иргэдийн нэр, оршин суугаа хаяг болон иргэдэд үнэт цаасны данс нээх асуудалтай холбогдох мэдээллийг гэрээний үндсэн дээр "Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-д шилжүүлэхийг Улсын бүртгэлийн еренхий газрын дарга Л.Менхбаатарт даалгасугай.

3. Монгол Улсын иргэн бүрт "Эрдэнэс Тавантолгой" компанийн 536 ширхэг хувьцааг нэг удаа үнэ төлбөргүйгээр эзэмшүүлэх ажлыг зохион байгуулахыг Төрийн емчийн хороо (Д.Сугар), "Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-ийн гүйцэтгэх захирал Т.Гандуулам нарт даалгасугай.

4. Иргэдэд үнэ төлбөргүй эзэмшүүлсэн хувьцааг нийтэд арилжаалах ажлыг Засгийн газраас "Эрдэнэс Тавантолгой" компанийн хувьцааг хоёр дахь зах зээлд арилжаалахыг зөвшөөрөн шийдвэр гарсны дараа эхлүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Төрийн емчийн хороо (Д.Сугар)-нд үүрэг болгосугай.

5. "Эрдэнэс Тавантолгой" компанийн хувьцааг тухайн иргэнд эзэмшүүлснийг хеделмор, халамжийн үйлчилгээний албадаар дамжуулсан Хүний хөгжил сангийн дэвтэрт тэмдэглэгээ бүхий наалт хийх арга хэмжээ авахыг Нийгмийн хамгаалал, хеделмерийн сайд Т.Гандид даалгасугай.

6. Иргэдийн Хүний хөгжил сангийн дэвтэрт тэмдэглэгээ бүхий наалт хийхэд шаардагдах 12.0 (арван хоёр) сая төгрөгийг Засгийн газрын неец сангваас гаргахыг Сангийн сайд С.Баярцогтод зөвшөөрсүгай.

7. Стратегийн хөрөнгө оруулагч болон оператор компанийн сонгон шалгаруулалт, түүний үр дүнд хийх ажлын явцыг харгалзан хувьцааг нийтэд санал болгох төлөвлөгөөтэй уялдуулан компанийн нэрлэсэн үнийн талаар санал боловсруулж, Засгийн газарт танилцуулахыг Төрийн емчийн хороо (Д.Сугар), "Эрдэнэс Тавантолгой" компанийн гүйцэтгэх захирал Б.Энзиши нарт даалгасугай.

8. "Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-ийг төрийн тусгай хамгаалалтад авахыг Тагнуулын еренхий газрын дарга Р.Болдод үүрэг болгосугай.

9. "Эрдэнэс Тавантолгой" компанийн хувьцааг иргэдээд эзэмшүүлэх, гадаад, дотоодын хөрөнгийн биржид арилжаалах бэлтгэл ажлын явцын талаар иргэдээд тодорхой мэдээлэл өгч, сургалт зохион байгуулахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Е.Отгонбаяр, Төрийн емчийн хороо (Д.Сугар). "Эрдэнэс Тавантолгой" компанийн гүйцэтгэх захирал Б.Энзиши нарт үүрэг болгосугай.

10. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд С.Баярцогт, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Хүрэлбаатар нарт үүрэг болгосугай.

11. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хувьцааг иргэнд эзэмшүүлэх, аж ахуйн нэгжүүдэд худалдахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2010 сны 12 дугаар сарын 29-ний өдрийн 350 дугаар тогтоолын 2.1 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРОНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Ч.ХҮРЭЛБААТАР

Хамт:

"Төрийн мэдээлэл" змэхтгэлийн редакци.
Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420, 329612

Хувьцаадний хуудас 3

Индекс: 14003

